

Т. Галсан

Үгэн Эм



Т. ГАЛСАН

ҮГЭН ЭМ ХЭМЭЭХ ҮЛГЭР
(Сургуулийн дунд насныханд)

“БНМАУ. Ардын боловсролын яамны Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар” Улаанбаатар хотноо 1986 онд эрхлэн хэвлүүлсэн
“ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД”
НОМООС

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар **Цагаан бамбарууш**
хэвлэлийн газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

-

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

Б
БОЛОР ДУРАН 2.0
АЛДАМ ШАЛГУУР

**“БОЛОР ДУРАН”
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР

ҮГЭН ЭМ ХЭМЭЭХ ҮЛГЭР

Улаанбаатар хотоо
Хүрээлэн байдаг
Уудам эх орноороо
Хүрээлүүлэн байдаг

Төв аймгийн
Нутагт юм гэнээ
Түүхт Угтаалын
Аж ахуйд юм гэнэ ээ.

Хүн бүл
Бахадмаар сайтай
Хөдөлмөрийн баатар
Магтмаар олонтой

Эгэл малчных нь
Ильичийн дэнлүүтэй
Үхэрчин, хоньчных нь
Өнгөт зурагттай

Өрмөн сүүгээ
Цахилгаанаар саадаг
Үс ноосоо
Цахилгаанаар хяргадаг

Манжин луувангаа
Машинаар хураадаг
Хээр талаа
Хиймэл бороогоор усалдаг

Төв аймгийн
Нутагт юм гэнэ ээ.
Түүхт Угтаалын
Аж ахуйд юм гэнэ ээ.

Үзээд үзээд
Чи ч олохгүй
Үс нь гэвэл
Ширхэг харгүй

Сахал нь харин
Алаг цооггүй
Цагаан ширхэг
Ганц ч байхгүй

Тодруулж зурвал
Сахал нь бараан
Толгой нь харин
Цасан цагаан

Чамин өвгөн
Амь зуудаг гэнэ ээ.
Загд гэдэг
Алдартай юм гэнэ ээ.

Урт чарга дээр
Суугаагүйгээс бус
Ууттай бэлэг
Сугавчлаагүйгээс биш

Алиа үнэг
Дагуулаагүйгээс биш
Алд таяг
Тулаагүйгээс бус

Өвлийн өвгөн
Яг мөн гэмээр
(Өмнөд туйл уруугаа
Явалгүй үлдчихэж гэмээр)

Тэр өвөө
Бүгдийг чаддаг гэнэ.
Тэрэгний дуугаар
Бүтэн эсэхийг нь таньдаг гэнэ.

Замд шуудрах
Хэрсүүхэн жолооч
Заавал машинаа
Чагнуулдаг гэнэ.

Хагалж бордсон
Талбайн шороог
Хар хүрэн
Талх юм шиг

Нандин гэгч
Имэрч үзээд
Намрынх нь ургацыг
Алдаагүй тогтоодог гэнэ.

Цагаан данхны
Сэнж булгарахад
Цагийн дотор
Ширээж гагнадаг

Загд өвөө
Тракторч хүүтэй
Зан сайт
Талхчин бэртэй.

«Тал ханхалдаг» гэж
Үрдээ хайртай
«Талх анхилдаг» гэж
Бэрдээ ч найртай.

Дүүрэн гэдэг
Ач хүүтэй
Дөрөвтэйдөө тэр нь
Уншиж сурсан гайхамшигтай.

Дөлгөөн гэдэг
Ач охинтой
Дөчин шүлэг

Аялгуулан унших нь гайхалтай.

Онц удахгүй
Сансарт нисэх хүү нь
Оддын хотхоноос
Аавтайгаа ярина.

Хааяа хааяа
Сайд охин нь
Хар тэргээр ирж
Сайхан аавдаа золгоно.

«ИРЖ АМАР!» гэж
Алтан Прагаас
Эрдэмтэн хүү нь
Аавыгаа урина.

Саяхан нэг
Сэтгүүлч хүү нь
Сархадтай хадагтай
Сийгүүлж иржээ.

«УЛСЫН НИЙСЛЭЛД
ТУХЛАН СУУРЫШ!» гэж
Улаан цайм
Тулган «шаарджээ»

— НИЙСЛЭЛ ХОТ
НАДААР ДУТАХГҮЙ
НЭГ НАСАНДАА БИ
УГТААЛААС УЙДАХГҮЙ

ХҮСЛЭЭ БИ
АНХ ЭНД ӨРГӨСӨН
ХӨЛСӨӨРӨӨ БИ
АТРЫГ УСЛАЛЦСАН,

НАРАА БИ
ЭНД ЖАРГААНА

ЯСАА БИ
ЭНД АМРААНА

ӨЛГИЙТЭЙ ХҮҮХЭД ШИГ
УЙГАГҮЙ АСАРСАН,
ӨРГӨМӨЛ ЖААЛ ШИГ
УГЖИЖ ТОРДСОН,

АЛИМЫН МОД МИНЬ
УРГАЦАА ӨГӨХ ДӨХЛӨӨ.
ААВ НЬ Ч БАС
УУЛАА ТҮШИХ ОЙРТЛОО.

АТГА ШОРОО
УГТААЛД ДУТВАЛ ЯАНА!
АЯНЫ ЗАМД
«УНТААД» ӨГВӨЛ ЯАНА! ГЭЭД

Оргож сэм
Зугтсан гэнэ ээ.
Овсгоот пионерууд
Нуусан гэнэ ээ.

Зооринд ороод
Цоожлуулсан гэнээ
ЛАВТАЙ НЬ ДЭЭР! гээд
Лацдуулсан гэнэ ээ.

Зузаан ултай
Гутал жийсэн
Зургийн аппарат
Гурвыг үүрсэн

Алаг шилтэй
Саравч зүүсэн
Англи оросоор
Сайхан ярьсан

Хээнцэр ахыг

Хүүхдүүд «тагнана»
ХЭЛЖ БОЛОХГҮЙ ШҮҮ! гэж
Хөмсгөө зангидна.

Аж ахуйн төвөөр
Зөндөө хэсээд
Аавынхаа нуугдсаныг
Зөнгөөрөө мэдээд

(Атрынхаа тосгоныг
Хайрлан бахадсан
Амжиж бас
Хэдэн зураг татсан)

Хашир сэтгүүлч
Уран арга зохиов гэнэ.
Хавийн жаалуудтай
Уриалагхан гэгч мэндлэв гэнэ.

СЭРГЭЛЭН ХҮҮХДҮҮД! гэж
Нийтээр нь магтав гэнэ.
— СЭРГИЙЛЭГЧ БОЛОХ УУ! гэж
Нэгээс нь шалгаав гэнэ.

Хэрсүү жаал
Гэнэдсэнгүй гэнэ.
— САНСАРТ НИСНЭ ЭЭ! гэхдээ
Сандарсангүй гэнэ.

АЛИМД ДУРТАЙ
ХҮҮХЭД БАЙНА УУ? гэж
Ажиггүй царайлан
Хүнд цүнхээ уудаллаа.

БАЙНА! БАЙНА! гэж
Охид уулгаллаа.
Баруун гараа
Хөвүүд өргөлөө.

Алим тараагаад
Сэтгүүлч инээлээ.
— ААВЫГ ХАРСАН УУ? гэж
Шивнэн асуулаа.

— МЭДЭХГҮЙ! МЭДЭХГҮЙ! гэж
Мэлзлээ, охид!
АЖААГҮЙ! АЖААГҮЙ! гэж
Андгайллаа, хөвүүд!

Эрснээ олдог
Бузгай авхаалжтан
Эцгийгээ ололгүй
Буцав гэнэ.

— ЗА БИД Ч
МУНДАГ ЮМ АА
ЗАЛГАМЖ ҮЕ Ч
МӨН ЮМ АА!

ЖАНЖИН СҮХИЙГЭЭ
ГАМИН, БАРОНД
ЗААЖ ӨГӨӨГҮЙ АРДЫН
УДАМ ЮМ АА! гэж

Хөөрөлхөн хөөрөлхсөөр
Хүүхдүүд гүйлээ.
Зоорь уруу очиж
Цоожийг онгойлголоо.

Найз жаалууд нь
Засаж өгсөн
Намхан орон дээр
Загд гуай сууна гэнэ.

Гараасаа салгадаггүй
Хүлээн авагчаар нь
Гадаад мэдээ
Хүнгэнэж байна гэнэ.

Өвөөгийн царай
Аймаар харагдав.
Өөдөсхөн радиогоо
Алгадаж унтраав.

— ДУУЛАВ УУ, ЦААНА ЧИНЬ
БАРУУН ЕВРОПТ
ДУНД ЗАЙН ПУУЖИН Б
БАЙРЛУУЛАХ БОЛЛОО

ДЭЛХИЙ ДАХИНЫ
ХОЁР ДАЙН
ДЭГДСЭН ТИВ
ЗЭВСГИЙН АГУУЛАХ БОЛЛОО! гэж

Нударга зангидан
Хий хий зангалаа.
Нуруу бөгтийн
Хэдэн мөч суулаа.

Тэгснээ гэнэт
Босоод ирэв гэнэ.
Тэвдсэн хүүхдүүд
Болжмор шиг бүлтгэнэв гэнэ.

«ГАНТАЙ ДАРЬ
ОРОН ГЭРТ ЧИНЬ БУУЛГАЯ
ГАЛЫН ЧИНЬ ЗАХАД
ОЙРХОН БУЛЪЯ» гэхэд

ТЭГ! ТЭГ! гээд
Арлаа өгдөг
Тэнэг эмгэн гэж
Английн ерөнхий сайдыг занав.

ХҮН ОВОГТООН! гэж
Гараа занган босов.
ХҮЧЭЭ НЭГТГЭН ТЭМЦЬЕ! гээд

Зүрхээ даран муурав.

Улаан бүчтэнүүд
Уйлан сандрав гэнэ.
Угтаал Цайдамынхан
Уймран сандрав гэнэ.

Батчулуун дарга
Эмч юм шиг
Баатар Алтанхүү
Хүү нь юм шиг

Загд өвгөнийд
Давхин ирцгээлээ.
Цаг алдалгүй
Түргэн дуудлаа.

Охид уйлангаа
Орчныг нь цэвэрлэнэ.
Төмөрчүүд гайхахдаа
Түлээг нь жиргэнэ.

— Аадар арилаад
Нар инээхэд
Алаг солонго
Найзуудаа даллахад

Хүүхдүүд бид
Хөл бөмбөг өшиглөдөг дөө!
Хөөрхий өвөө минь
Хаалгач болдог доо!

Эгзэгтэй үед
Хаалгаа орхиод
Эсрэг тал руу
Халз довтолдог доо!

Ахин олдошгүй
Дархан хаалгач

Амьсгал хураавал
Даан ч харамсалтай яа! гэж

Аж ахуйнхаа
«ТРАКТОР» багийг хожсон
Аймгийн тэмцээнд
Тавдугаар байр эзэлсэн

«ХАРЦАГА» багийн
Ахлагч гуниглалаа.
ХАЙРАН ӨВӨӨ! гэж
Асгартал уйллаа.

— Айлын зурагт
Эвдэрч эрээлжлээд
Адал явдалт кино
Эхлэх шахаад

Хүүхэд багачууд
Уйлагнах үед
Хүсүүрхэлгүй ирээд
Удаалгүй засчихдаг

Өвөө минь хөөрхий
Үхвэл яана аа?
Ондоо тийм өвөө
Олдохгүй, яана аа? гэж

Бодь-Өнөр
Бодлогошрон сууна.
Нуух гээд болохгүй
Нулимс нь бөмбөрнө.

— Үдэш болж
Од түгүүт бид
Өтгөн цэцэрлэгтээ
Олуулаа цугладаг сан

Хүндэт өвөө

Мөнгөн царс шиг
Хүүхэд бид
Мөчирт шавсан болжмор шиг .

Нэг доороо
Бөөгнөдөг сөн дөө!
Ний нуугүй
Хууч хөөрдөг сөн дөө!

Зургаан мянган
Үлгэр мэддэг
Зуун түмэн
Үндэс таньдаг

Мэргэн өвөөгөөс
Алт унах шиг болдог сон.
Мэдэхгүй бүхнээ
Асууж лавлах сайхан сан.

«За битгий
Шулганаад бай» гэж
Зарим ээж шиг
Загнахгүй нь эелдэг.

Цалинтай багшаараа
Учрыг нь хэлүүл! гэж
Залхуу аав шиг
Уурлахгүй нь элэгсэг сэн.

Ах бол өвөөг
Радиогийн тоймч гэдэг сэн
Эгч бол өвөөг
Эрдэмтэн Доулийн толгой гэдэг сэн!

Өвөө минь
Өвдөх ч ёсгүй! гэж
Өрөвч Тэгшзаяа
Үе үе шүүрс алдана.

«ӨВӨӨ ЗАГД
ӨВДЛӨӨ!» гэсэн зар тархсаар л...
Орчны хүмүүс
Од унасан шиг сандарсаар л...

Сүүлтэй ууц
Хоньчин нь авчрав.
Сүүтэй домбо
Саальчин нь авчрав.

Өвөөгийн тэнхээ
Ямаршуухан байгааг
Үнэн шударгаар
Яв цав мэдээлэхийг

Бүлгийн дарга нь
Дөлгөөнд даалгажээ.
Бүлгэмийн зөвлөл нь
Дүүрэнд даатгажээ.

Хатуу даалгавартай
Дөлгөөн охин
Хараацай нисэх шиг
Дүүлэн дэгдэн ирлээ.

«УХААН ОРЛОО!» гэж
Холбоочин мэдээлэв,
Ура хашхирч
Хотлоороо баясав.

Үхэл гэдгийг
Аюулгүй гэж боддог
Өөр гариг руу
Аялах л гэж ойлгодог.

Дүрзээ хүү
Ишиг тэвэрсээр ирлээ.
Дөлгөөнд хандан
Ингэж шууд зөвлөлөө.

— Өвөө, үзэм идээд
Шүд нь өвдөө юу?
Өрөвсөж дэндээд
Буйл нь хавдаа юу?

Хөвөнтэй аналгин
Араанд нь зуулгаач!
Хүйтэн жин
Шанаанд нь тавиач! гэлээ.

«ХИЙМЭЛ ШҮД
ХОРХОЙТДОГГҮЙ юм.
ХЭЗЭЭ Ч ГЭСЭН
ӨВДДӨГГҮЙ ЮМ!» гэж

Томчуудын нэг нь
Дүрзээд хэллээ.
«ТОМООГҮЙ БАЙНА ДАА
ДҮҮ МИНЬ!» гэж өхөөрдлөө.

Морины толгой
Өвөөгөөр сийлүүлээд
Модон шилбүүрт
Үхлүүт углуургадуулаад

Айлын хооронд
Давхиж явдаг
«АДУУЧИН БОЛНО ОО ХӨ!» гэж
Дандаа хөөрдөг

Дүгрээ хүү
Шувуун сааралтайгаа ирлээ.
Дөлгөөнд хандан
Шууд ингэж асуулаа.

«ЭНХ ТАЙВНЫ
БЭЛЭГ ТЭМДЭГ
ЭВТЭЙ ДӨРВИЙГ

.. ..

СИЙЛЖ БАЙГААД

ХУРЦ ХУТГА НЬ
ХАЛТИРАА ЮУ?
ХУРУУНЫХ НЬ ӨНДГИЙГ
ХАЛЬСЛАА ЮУ?

Шатаасан хөвөн
Одоохон бэлдээч!
Шарх дээр нь
Ойчихооргүй наагаач!

Айдас түгшүүр нь
Дундарсан пионериуд
Адуучин Дүгрээг
Дугуйран бүсэлтэл

Шувуун саарлынх нь
Өргөн зоон дээр
Сундлах санаатай
Үсрэн цоройлтол

Аахилсаар Дүүрэн
Гүйж ирэв гэнэ.
«АХИАД МУУДЛАА» гэж
Гүвтнэн шивнэв гэнэ.

Гэгээн өдрийн
Цэлмэг тэнгэрт
Гийсэн нар
Жаргах шиг боллоо.

«Өвдсөнийг эдгээдэг
Эмч л больё» гэж
Өчнөөн хүүхэд
Энээхэн зуур бодлоо.

Өвөөг дагаж
Өглөө болгон гүйдэг

Өвлийн хүйтнээр
Өрхтэй харзанд ордог

Цас орохоор
Пионерууд шиг баярладаг
Чармай нүцгэлээд
Хунгар дээр хөрвөөдөг

Дугар гуай, Загд гуайнд
Хар гүйхээрээ оров гэнэ.
Дуугаа хураасхийн
Хажууд нь очив гэнэ.

«ТЭНХЭЭ ТАМИР Ч
ДАЖГҮЙ БИЗ ДЭЭ!» гээд
Дэрийг нь засаж
Духыг нь дарлаа.

Цаг хүргэлгүй
Өвчнийг намжаадаг
Цагаан эм
Өвөөгийн гарт атгууллаа.

Өвөө түүнийг нь
Үүд рүү шидлээ.
Бөөрөнхий үрэл
Бөндгөнөн өнхөрлөө.

«НАЙЗ ДУГАР МИНЬ
ЭМ АШИГГҮЙ!
НАМАЙГ СЭХНЭ!» гэж
ИТГЭСНИЙ ХЭРЭГГҮЙ

Улайрсан бухаас
Зөрүүд зөнөг
Удмаа устгахаас
Буцахгүй тэнэг

Цадиггүй дайнчид л

Намайг аллаа.
Цагаан ордны
Хар гэмтэн л буудлаа.

Үхлийн зэвсгийг
Европт биш
Өр зүрхэн дээр минь
Тэр л байрлууллаа.

Тив хотойм
Тэр ачааг
Алуурчин Гитлерээс шархтай
Алаг зүрх даахгүй нь ээ...

...Атрын түүхийг
Бичиж байгаад
Арваад хуудас
Дутуу орхилоо.

Дугар минь түүнийг
Бушуу гүйцээгээрэй! гээд
Дуугаа хурааж
Буруу харлаа.

Талхчин бэр нь
Енгинэтэл уйлав.
Тракторч эр
Эхэр татав.

Дүүрэнгийн найзууд
Түрж орилов.
Дөлгөөний найзууд
Бүр ч чарлав.

Үлгэрт гардаг
Муухай чөтгөр
Өвөөгийн хажуугаар
Мяраагаад ч байх шиг

Үл үзэгдэх
Улаан ишт балиусаа
Өр зүрх руу нь
Далайгаад ч явах шиг

Гэр дотор
Давчхан болов гэнэ.
Гэрэлтэй атал
Харанхуй санагдав гэнэ.

Зуухаа галлахаа
Ээж нь мартсан үеэр
Зурагтаа үзэхээ
Цөм мартсан цагаар

Ув улаан
Нэмэх тэмдэгтэй
Улалзаж далласан
Гэрлэн дохиотой

Ямбалан унтмаар
Ханзан ортой
Явуутаа ярьдаг
Харилцуур угастай

Цагаан тэрэг
Давхиад ирэв гэнэ.
Залуухан эмч
Түүгээр ирэв гэнэ.

Өвөөгийн дэргэд
Дэд эрдэмтнийг очуут
Үхэл гэрээс
Дэгдээд гарах шиг болов гэнэ.

Эрх жаал шиг өвөө
Ёолж ёхлов гэнэ.
Эмч харин
Илэн таалан үзэв гэнэ.

Араа шүдийг нь
Тоолдог ч юм уу
Амыг нь том
Ангайлгалаа гэнэ.

Тоос эс
Торсон гэж санаа юу
Доод зовхийг нь
Дордойлгож ажлаа гэнэ.

Одон бөмбөг
Тэнд бий гэж санаа юу
Олгой гэдсийг нь
Тэмтэрч үзэв гэнэ.

Урьд нь хараагүй
Чамин багажаар
Уушги зүрхийг нь
Чагнан оношлов гэнэ.

Эмч тэгснээ
Эелдэгхэн мишээлээ.
Ээж, аав сая л
Галаа асаахаар ухасхийлээ.

Дөлгөөн охин
Зурагтаа асаалаа
Дүүрэн сая л
«ЗУСЛАНГИЙН НАЙЗУУД»¹ гэж шивнэлээ.

Уушги зүрх чинь
Арслангийнх шиг байна.
Уулчин залуу ч
Атаархмаар байна.

Шөрмөс булчин чинь
Шандастай байна.
Сумын зааныг ч

Дүүгүүрдмээр байна гээд

Цэнхэр хөвчийн
Зоргол шиг хөөрхөн биетэй
Цэенпил эмч
Зориуд мөрийг нь алгадлаа.

— ХОТООС ТАНЬ ДЭЭР
«САХИЛГАГҮЙ» ЗОЧИН ИРЖЭЭ.
ХОРЗ Ч ЮМ УУ
САРХАД АВЧ ИРЖЭЭ.

ХОЁР, НЭГ ХУНДАГА
ИСГЭЛҮҮН ЮМ, ТА АМСЖЭЭ
ХОЛ ОЙРООС БАС
ЭВГҮЙ мэдээ сонсжээ.

АРХИ ГЭДЭГ
ҮНЭХЭЭР ХОР!
АМ РУУ ОРООД Л
ӨРГӨСТЭЙ ТОР! гэхэд...

«МЭДЧИХЖЭЭ! гэж
Өвөө шивнэв.
«МИНИЙ Л БУРУУ!» гэж
Үнэнээсээ гэмшив.

САНАА СЭТГЭЛЭЭР
БҮҮ УНААРАЙ
САРХАД БИШ
СҮҮ УУГААРАЙ

ДАЖГҮЙ ТА
ЗУУН ТАВЬ НАСАЛНА
ДАЛАН ЗУНЫ
ЗУГААТ НААДАМ ҮЗНЭ» гэж

Үнэн сэтгэлээсээ
Эмч хэллээ.

Өвөө ухасхийн
Эрдэмтнийг үнслээ.

«ЭРҮҮЛ ХҮНД
ТҮРГЭН ДУУДСАН!» гэж
Энэрэл бүрэн
Даргыгаа зэмлэлээ.

ИДЭЭН ДЭЭЖ
— ТОГТООЧИХ ДОО! гээд
Эмчид өвөө
Хугас шилтэйгээ өглөө.

«БАЯРЛАЛАА! гээд эмч
Шилтэй цэнхрийг авлаа гэнэ.
Паалантай төмпөнд
Архиар гараа угаалаа гэнэ.

«АРИУТГАЛД БОЛ
ХЭРЭГТЭЙ ЭД!» гэж
Архийг Цэенпил
Хээвнэг магтав гэнэ.

«СЭЛМЭЭС ИРТЭЙ
ТАВХАН ҮГЭЭР
СЭТГЭЛИЙН ХӨВЧИЙГ
ТАСАЛЖ МЭДНЭ.

ЭМЭЭС ХҮЧТЭЙ
АРВАН ҮГЭЭР
ЭМГЭГ ХУУЧИЙГ
АНАГААЖ Ч БОЛНО

ҮРЛЭН ЭМД
ЭДГЭЭГҮЙ ӨВӨӨГ
ҮГЭЭР АНАГААСАН
ЭРДЭМТЭНД БАЯРЛАЛАА!» гэж

Санал гомдол

Бичдэг дэвтэр дээр
Сайшаал талархлаа
Багчулуун гуай дэвшүүлээ.

Ув улаан
Нэмэх тэмдэгтэй
Улалзаж далласан
Гэрлэн дохиотой

Ямбалан хажуулмаар
Ханзан ортой
Явуутаа ярьдаг
Харилцуур утастай

Цагаан тэрэг
Эргээд давхилаа гэнэ.
Замын машинууд
Зай тавилаа гэнэ.

Амтаг сүүгээ
Цахилгаанаар саадаг
Ахар, ноосоо
Цахилгаанаар хяргадаг


Хээр талаа
Хиймэл бороогоор усалдаг
Манжин луувангаа
Машин зарцалж хураадаг

Эгэл малчных нь
Ильичийн дэнлүүтэй
Үхэрчин, хоньчных нь
Өнгөт зурагттай

Төв аймаг руу
Аяны зам хөвөрлөө гэнэ.
Түргэний тэрэг
Алсын хөтлөөр давлаа гэнэ.

«ҮГЭН ЭМ»
Дуулаагүй нэртэй
Үлгэр ч ингээд
Дуусав гэнэ ээ.

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.



Өглөгийн эзний сонорт



Та манай номын санд хандив өргөж болно.

Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Орау

**1986 онд БНМАУ-ын Ардын боловсролын яамны Сурах бичиг,
сэтгүүлийн нэгдсэн редакцын газар эрхлэн хэвлүүлсэн
“ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД” номын Гарчиг :**

“Цэнхэр эргүүлийнхэн буюу анхны гавьяа” хэмээх үлгэр

“Зөвлөлт хүн буюу улаан туг” хэмээх үлгэр

“Үгэн-эм” хэмээх үлгэр

“Хурдан байшин буюу олондоо тустай ойн автобус” хэмээх үлгэр

“Зуны амралт буюу явдаг дэлгүүр” хэмээх үлгэр

1986 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл :

Т. ГАЛСАН

ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД

(Сургуулийн дунд насныханд)

Редактор *С. Надмид*

БНМАУ

Ардын боловсролын яамны

Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар

Улаанбаатар 1986 он

Хэвлэлийн редактор Ц. Сүхбаатар

Уран сайхны редактор П. Оюунцэцэг

Зураач Б. Төмөрбат

Техник редактор Р. Оюун

Хянагч Д. Цэнд-Аюуш, Д. Шүр

А № 96263

За № 186

ХГ № 40/86

Өрөлтөд 1986 оны 6 сарын 2-нд

Хэвлэлтэд 1986 оны 7 сарын 5-нд

Цаасны хэмжээ 84x108/32

Х. х. 3

ХНХ 5.04

Хэвлэсэн тоо 6000

Үнэ 2 тө.

Улаанбаатар 46

*АБЯ-ны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцын газар Их сургуулийн
гудамж 3*

Д. Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинатад хэвлэв.

Д. Сүхбаатарын талбай 2

Заметки

[←1]

Хүүхдийн кино